



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/87

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Магсаржав багийн 2 дугаар гудамжны 02 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Бяруузанын Доржсүрэн /ИЭ78120475/-ийн эзэмшлийн 876.9 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу “Мөнхбаян-эрдэнэ” ХХК /4064844/-д мэдээллийн сангийн зургийн дагуу 1081 метр квадрат, орон сууцны зориулалттай, хаягийг Баянгол 3 дугаар гудамжны 300 тоот болгон 11 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгж байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/87 Ch  
02 00381